



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Сургалтын төлбөр, бусад төлбөр
хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт, Монгол Улсын Их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.3, 3.4, 4.1.5 дахь заалт, Монгол Улсын Их сургуулийн дүрмийн 5.2.3.5 дахь заалт, Монгол Улсын Их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их сургуулийн 2026-2027 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдөх 2026-2027 оны хичээлийн жилд элсэгчдийн бакалаврын хичээлийн нэг багц цагийн төлбөрийг нэгдүгээр хавсралтаар; 2025-2026 оны хичээлийн жилд элсэгчдийн бакалаврын хичээлийн нэг багц цагийн төлбөрийг хоёрдугаар хавсралтаар; 2024-2025 оны хичээлийн жилд элсэгчдийн бакалаврын хичээлийн нэг багц цагийн төлбөрийг гуравдугаар хавсралтаар; 2024-2025 оны хичээлийн жилээс өмнө элсэгчдийн бакалаврын хичээлийн нэг багц цагийн төлбөрийг дөрөвдүгээр хавсралтаар; ахисан түвшний хичээлийн нэг багц цагийн төлбөрийг тавдугаар хавсралтаар; гадаад оюутны хичээлийн нэг багц цагийн төлбөрийг зургаадугаар хавсралтаар; хамтарсан хөтөлбөр хичээлийн нэг багц цагийн төлбөрийг долоодугаар хавсралтаар; зэргийн бус сургалтын төлбөрийн хэмжээг наймдугаар хавсралтаар; оюутны дотуур байрны төлбөрийг есдүгээр хавсралтаар; үйлчилгээний бусад төлбөр хураамжийг аравдугаар хавсралтаар; лабораторийн шинжилгээний төлбөрийг арван нэгдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Монгол Улсын Их сургуулийн цахим номын санг гадаад, дотоодын уншигчдад ашиглуулах үйлчилгээний төлбөрийг арван хоёрдугаар хавсралтаар, цүнх, эд зүйл хадгалах шүүгээ (локер) ашиглалтын төлбөрийг арван гуравдугаар хавсралтаар тус тус баталж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 13 дугаар тогтоолын есдүгээр хавсралтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, бусад хавсралтыг 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын их сургуулийн ректор (Б.Очирхуяг)-т даалгасугай.

ДАРГА



Х.БАТЖАРГАЛ

1425010048

Монгол улсын их сургуулийн Удирдах
зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын
25...-ны өдрийн 30 дугаар тогтоолын
09. дугаар/дүгээр хавсралт

ОЮУТНЫ ДОТУУР БАЙРНЫ ТӨЛБӨР

ATA13089 9104399
9024080427

№	Оюутны байр	Өрөөний багтаамж, зориулалт	Нэг оюутны төлбөр		
			Сарын төлбөр	Хагас жилийн төлбөр*	Жилийн төлбөр
Улаанбаатар	I байрны /1-3 давхар/	4 оюутны		625,000	1,250,000
	I байрны 4-р давхар /Ахисан түвшний оюутан/	2 оюутны	270,000		2,700,000
	II байрны /1-4 давхар/	2 оюутны			3,360,000
	III байрны /1-4 давхар/	4 оюутны		625,000	1,250,000
	V байрны /1 давхар/	2 оюутны	270,000		2,700,000
	V байрны /2-р давхар/	4 оюутны		660,000	1,320,000
	V байрны /3, 4 давхар/	4 оюутны			1,320,000
	VI байрны /1-4 давхар/	4 оюутны			960,000
	II байр /нэг өрхийн байр/	нэг өрх	542,000		
	III байр /нэг өрхийн байр/	нэг өрх	398,000		
Орон нутаг	Завхан аймаг дахь бизнес, мэдээллийн технологийн сургуулийн оюутны дотуур байр	2 оюутны			1,250,000
		3 оюутны			1,110,000
		4 оюутны			1,050,000
		4-с дээш оюутны			1,030,000
	Баруун бүсийн сургуулийн оюутны дотуур байр	1 оюутны			1,270,000
		2 оюутны			760,000
		3 оюутны			640,000
		4 оюутны			510,000
		Түр оршин суугч	60'000төг х 30хоног		-
	Зүүн бүсийн сургуулийн оюутны дотуур байр	1 оюутан			950,000
		2 оюутны			880,000
		3 оюутны			820,000
		4 оюутны			760,000
		Нэг айл, өрх	440,000		
		Түр оршин суугч	60'000төг х 30хоног		

Ес дүгээр хавсралтын үргэлжлэл



ГАДААД ОЮУТНЫ ДОТУУР БАЙРНЫ ТӨЛБӨР

№	Гадаад оюутны байр	Өрөөний багтаамж, зориулалт	Нэг оюутны төлбөр	
			Сарын төлбөр	Жилийн төлбөр
Улаанбаатар	I байрны 4 давхар	1 оюутны	540,000	5,400,000
		2 оюутны	270,000	2,700,000
		3 оюутны	183,000	1,830,000
	IV байрны бүх давхар	1 оюутны	540,000	5,400,000
		2 оюутны	270,000	2,700,000
		3 оюутны	183,000	1,830,000
	Магистр, докторын түвшний оюутан /II байрны 4 давхар/	1 оюутны	672,000	6,720,000
		2 оюутны	336,000	3,360,000
	Түр оршин суугч /өдрийн/		53,000	
Орон нутаг	Завхан салбар сургуулийн оюутны дотуур байр	1 оюутны	250,000	2,500,000
		2 оюутны	126,000	1,260,000
	Дорнод, Ховд сургуулийн оюутны дотуур байр	1 оюутан	-	874,000

Тайлбар: * Хагас жилийн төлбөр нь зөвхөн нэг улирал сурах оюутанд хамаарагдана.

Оюутан 5 сараас дээш хугацаагаар оюутны байранд амьдарсан бол төлбөрийн буцаалт хийгдэхгүй.